

## **ХЯТАД, МОНГОЛЫН НАМ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ХӨГЖИЛ**

*Э.Наран\**

2009 он бол Хятад, Монголын найрсаг харилцааны хөгжлийн түүхэнд онцгой нэгэн он болно. 2009 он нь Хятад, Монгол хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, хоёр улсын харилцаа, хоёр улсын нам хоорондын харилцаа хэвийн болсны 20 жил, түүнчлэн “БНХАУ, Монгол Улсын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ”-г шинэчлэн байгуулсны 15 жилийн ой давхцсан ойн жил юм. Сүүлийн 20 жилийн дотор хоёр улсын хооронд шинэ хэлбэрийн нам хоорондын харилцаа үүсч байгуулагдан хөгжиж байгаа нь хоёр улсын харилцааг тогтвортой, хурдацтай хөгжихөд ихээхэн түлхэц үзүүлж байна.

### **Нэг. ХКН-ын нам хоорондын харилцааны зарчим**

#### 1. Шинэ хэлбэрийн нам хоорондын харилцаа

31 жилийн гэртээ ХКН-ын 11 дэх удаагийн III бүгд хурлаас хойш Хятад улс өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлого руу шилжиж, социализмын орчин үеийн шинэ цаг үе рүү алхан оров. Дэн Сяопин тэргүүтэй ХКН-ын удирдлага олон улсын нөхцөл байдалд шинжлэх ухаанчаар дүгнэлт хийсний үндсэн дээр, олон улсын коммунист хөдөлгөөний түүхээс олсон туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэж, “тусгаар тогтносон-бие даасан, бүрэн эрх-тэгш эрхтэй, харилцан биенээ хүндэтгэсэн, дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох” шинэ хэлбэрийн нам хоорондын харилцааны 4 зарчмыг дэвшүүлэн тавьсан.

ХКН-ын нам хоорондын харилцааны 4 зарчим: Тусгаар тогтносон, бие даасан гэдэг нь шинэ хэлбэрийн нам хоорондын харилцааны үндэс суурь юм. ХКН нь бүх улс орнуудын улс төрийн намуудын тусгаар тогтносон, бие даасан байр суурь болон өөрийн улсынхаа нийгмийн тогтолцоо, сонгосон хөгжлийн замыг бүрнээ хүндэтгэнэ. Бүрэн эрх, тэгш эрх гэдэг нь шинэ хэлбэрийн нам хоорондын харилцааны гол зүйл мөн. Намуудыг том, жижиг гэж ялгалгүй, эрх тэгш хандах ёстой бөгөөд аливаа улс төрийн нам нь өөрийнхөө үзэл баримтлал, үйл ажиллагааг бусад намд тулган хүлээлгэж болохгүй. Харилцан биенээ хүндэтгэх гэдэг нь шинэ хэлбэрийн нам хоорондын харилцаа тогтоох урьдач нөхцөл мөн. Бүх намууд нь бусад улсын нам, ард түмний туршлага, тэр улсын нөхцөл байдал, намын сонгосон дотоод, гадаад бодлогыг хүндэтгэх ёстой. Дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох гэдэг нь шинэ хэлбэрийн нам хоорондын харилцааг хөгжүүлэх баталгаа мөн. Намуудын дотоод үйл

\* Э.Наран - БНХАУ-ын ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургууль, доктор (Sc.D), профессор

хэрэг нь гадаадын аливаа улс төрийн намын оролцоогүйгээр өөрсдөө шийдвэрлэх ёстой бөгөөд нам хоорондын харилцааг ашиглан өөр улсын дотоод байдалд хөндлөнгөөс оролцож болохгүй гэж заасан.

## 2. ХКН-аас гадаад улс орнуудын улс төрийн намуудтай харилцаж буй байдал

ХКН нь гадаадтай нам хоорондын харилцааны 4 зарчмыг баримталж буйн хувьд олон улсын харилцаанд түүний дотор Монгол Улсын улс төрийн намуудыг багтаасан дэлхийн олон улс төрийн намуудын ойлголцол, дэмжлэгийг хүлээж байна. 2008 оны эцэс гэхэд ХКН нь дэлхийн 160 гаруй улсын 500 гаруй<sup>1</sup> улс төрийн нам, улс төрийн байгууллагатай өөр өөр хэлбэрийн найрсаг харилцаа, холбоотой ажиллаж байна. Тэдгээрийн дотор төрийн эрх баригч нам, засгийн газрыг бүрдүүлэгч улс төрийн нам багтаж байгаа төдийгүй томоохон сөрөг нам, түүнчлэн Хятад улстай дипломат харилцаагүй улс орнуудын намууд ч багтаж байна. Өөрөөр хэлбэл, коммунист ажилчны нам ч байна, социал, үйлдвэрчдийн нам болон консерватив нам ч байна. Түүнчлэн Европ, Япон зэрэг хөгжингүй орнуудын улс төрийн нам, Ази, Африк, Латин Америк хөгжиж буй орнуудын улс төрийн намуудтай ч харилцаж байна.

Сүүлийн жилүүдэд намуудын гадаад харилцаа нь олон талт харилцааг улам бүр чухалчлан үзэх болж байна. 2004 оны 9 дүгээр сард ХКН-аас Азийн улс төрийн намуудын 3 дахь симпозиумыг зохион байгуулж, уг хуралд 35 улсын 81 улс төрийн нам, улс төрийн байгууллагуудын тэргүүн нар болон төлөөлөгчид оролцож, Ази тивийн улс төрийн намуудын эв нэгдэл, хамтын ажиллагааг уриалсан “Бээжингийн Тунхаглал”-ыг гаргасан. Энэ үеэр ХКН нь улс төрийн намуудын олон талт харилцааг үүсгэгч нам гэгдэв. Энэ олон улсын хуралд МАХН, Монголын Иргэний Зориг нам, Монголын Ардчилсан нам гэсэн 3 намын төлөөлөгчид урилгаар ирж оролцсон.

### **Хоёр. Хятад, Монголын нам хоорондын харилцааны хөгжил**

1. Хятад, Монголын нам хоорондын харилцаа сэргэсэн нь  
1989 оны 7 дугаар сард ХКН-ын Гадаад харилцааны газрын дарга Жу Лян Монгол Улсад урилгаар айлчилсан нь ХКН, МАХН-ын хооронд 30 шахам жил тасраад байсан харилцаанд албан ёсны анхны уулзалт болж, энэхүү айлчлалаар хоёр нам албан ёсоор нам хоорондын харилцаагаа сэргээсэн юм.

1991 оны 1 дүгээр сард МАХН-ын дарга Г.Очирбат БНХАУ-д айлчлав. ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Зян Зэминь Г.Очирбат болон дагалдан яваа хүмүүсийн хамтаар уулзсан нь хоёр

намын дээд удирдлага 30 гаруй жилийн дараа болсон анхны уулзалт болов. Тун удалгүй 2 дугаар сард нь ХКН-ын Төвийн хорооны гишүүн, ӨМӨЗО-ны Коммунист намын нарийн бичгийн дарга Ван Цюнь ХКН-ын төлөөлөгчийн хувиар МАХН-ын XX Их хурал, МАХН байгуулагдсаны 70 жилийн ойн арга хэмжээнд тус тус оролцов. Мөн оны 11 дүгээр сард МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Багабанди БНХАУ-д айлчлав. Өөрөөр хэлбэл, нэг жил хоёр улсын намуудын дээд удирдлага 3 удаа уулзсан билээ.

1995 оны 2 дугаар сард МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Даш-Ёндон тэргүүтэй МАХН-ын төлөөлөгчид БНХАУ-д айлчлав. Б.Даш-Ёндон хэлэхдээ, эдүгээ дэлхий дээр хамгийн хүчирхэг, бодит хүчин чадалтай улс төрийн хүчин бол Хятадын Коммунист Нам бөгөөд дэлхийн коммунизмын үйл хэргийн ирээдүй зөвхөн ХКН-д тулгуурлана гэж үзсэн.

## 2. Нам хоорондын харилцаа бол улс хоорондын харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг

Шинэ зуун руу орсноор Хятад, Монголын улс төрийн намуудын харилцаа ч идэвхитэй хөгжлийн шинэ үе рүү алхан орсон юм. 2000 оны 10 дугаар сард ХКН-ын ТХ-ны УТТ-ны БХ-ны гишүүн, Нарийн бичгийн дарга нарын газрын дарга Вэй Зяньсин урилгаар Монгол Улсад айлчилсан нь хоёр улсын нам хоорондын харилцааны хөгжил шинэ эрч хүч өгөв. Вэй Зяньсин МАХН-ын дарга Н.Энхбаяртай уулзахдаа, нам хоорондын харилцаа бол улс хоорондын харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм гээд МАХН нь Хятад, Монголын найрсаг харилцааг хөгжүүлэхэд тууштай хүчин зүтгэж ирснийг сайшаасан юм. Н.Багабанди Ерөнхийлөгч Вэй Зяньсин тэргүүтэй ХКН-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзах үеэр, Хятадын Засгийн газар Монголын ард түмний сонгосон хөгжлийн зам, Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзэж, Монгол Улсын дэвшүүлсэн Монголын нутаг дэвсгэрийн цөмийн зэвсэггүй бүс байгуулах саналыг дэмжиж ирсэнд талархал илэрхийлж, Монгол Улс Тайвань, Түвдийн асуудлаар Хятадын Засгийн газрын байр суурийг цаашид ч дэмжихээ дахин нотолсон юм.

Вэй Зяньсин дарга мөн Монгол Улсын Их Хурлын дарга, МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Энэбиштэй уулзах үеэр, Хятад, Монгол хоёр улсын нийгмийн тогтолцоо хэдийгээр өөр, хоёр намын үзэл баримтлал, сэтгэлгээний талаар ялгаатай ч гэсэн энэ нь бидний найрсаг харилцаанд огтхон ч саад болохгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн.

2003 оны 6 дугаар сард ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсад анх удаагаа төрийн айлчлал хийсэн нь Хятад улсын шинэ үеийн удирдлага найрсаг

хөрш, түнш хөршийн бодлого чиглэлээ тууштай баримталдгийн илэрхийлэл болов. Айлчлалын үеэр хоёр тал Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн, түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлэхээ тунхаглаж, хоёр улсын харилцааг хөгжлийн шинэ түвшинд ахиулсан. “БНХАУ, Монгол Улсын хамтарсан мэдэгдэл” гаргаж, хоёр тал харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхээ зөвшөөрч, байгалийн баялгийн нээн олборлолт, дэд бүтцийн бүтээн байгуулалт нь хоёр улсын хамтын ажиллагааны цаашдын голлох салбар болгон тогтоов.

2006 оны 4 дүгээр сард Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баяр тэргүүтэй МАХН-ын төлөөлөгчид Хятад улсад айлчлав. ХКН-ын Төв Хорооны УТТ-ны БХ-ны гишүүн, БНХАУ-ын дэд дарга Зэн Цинхун төлөөлөгчидтэй уулзах үеэр, сүүлийн жилүүдэд хоёр улсын харилцаа бүх талаар идэвхтэй хөгжиж, улс төрийн итгэлцэл тасралтгүй бэхжиж, харилцан ашигтай хамтын ажиллагаа улам бүр гүнзгийрч, хөгжлийн хэтийн ирээдүйтэй байгааг онцлон тэмдэглэж, Хятад улс олон жил дараалан Монгол Улсын хамгийн том худалдааны болон хөрөнгө оруулагч түнш улс болж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь хоёр улсын ард түмэнд бодит ашиг тусыг өглөө гэв.

Хятад улстай найрсаг харилцаагаа хөгжүүлэх нь Монголын Засгийн газар, гадаад бодлогын тэргүүлэх чиглэл бөгөөд эрх баригч намын хувьд МАХН нь ХКН-тай харилцаа, хамтын ажиллагаага бэхжүүлж, хоёр улсын харилцааг эрүүлээр хөгжүүлэхэд шинэ хувь нэмэр оруулахад бэлэн байгаагаа Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баяр цохон тэмдэглэв.

2009 оныг Хятад, Монгол хоёр улсын нам хоорондын харилцааны хөгжил нь харьцангуй өндөр түвшинд хүрсэн он гэж хэлж болохоор байна. 2009 оны 6 дугаар сард ХКН-ын УТТ-ны БХ-ны гишүүн, ХКН-ын Сахилга бат, хянан шалгах хорооны дарга Хэ Гуоцянь Монгол Улсад урилгаар айлчлав. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга болон Монголын улс төрийн гол намуудын удирдлагууд Хэ Гуоцянь тэргүүтэй ХКН-ын төлөөлөгчидтэй уулзав. Хэ Гуоцянь Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийг Хятад, Монгол хоёр улсын харилцааг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч байдагт сайшааж, талархал илэрхийлэв. Эдүгээ хоёр улсын харилцаа түүхийн маш чухал, ховор боломжтой үед ирээд байгаа тул хоёр тал харилцааг хайрлан хамгаалж, Хятад, Монголын харилцааг ирээдүй руу чиглүүлэн хөгжүүлэхэд улам бүр түлхэц болох ёстойг онцлон тэмдэглэв. Тэрбээр мөн хоёр талын хамтын хүчин чармайлтаар Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн, түншлэлийн харилцаа шинэ түвшинд ахиж чадна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол Улс урьдын адил “Нэг Хятад”-ын бодлогыг тууштай баримталж, Хятадын Засгийн газрын Тайвань, Түвдийг хөндсөн асуудлаарх байр суурыг тууштай дэмжихээ дахин нотлов.

### 3. ХКН нь Монголын шинээр хөгжиж байгаа намуудтай харилцаагаа чухалчлан үздэг

ХКН-ын МАХН-тай уламжлалт харилцаагаа хадгалахын зэрэгцээ Монголын шинэ тутам үүсч хөгжиж байгаа намуудтай харилцаа тогтоож байна. 1998 оны 11 дүгээр сарын 12-нд МСДН, МҮАН-ын төлөөлөгчид дараалан Хятад улсад айлчлав. Энэ бол Монголын ардчилсан намын төлөөлөгчдийн Хятадад хийсэн анхны айлчлал байв. 2003 оны 11 дүгээр сард М.Энхсайхан тэргүүтэй МАН-ын төлөөлөгчид Хятад улсад айлчилж, ХКН-ын УТТ-ны БХ-ны гишүүн У Гуаньжэнтэй уулзсан юм. Монголын бүх сөрөг хүчний намууд “Нэг Хятад”-ын зарчмыг тууштай сахиж, хоёр улсын бүхий л салбар дахь найрсаг хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд идэвхтэй дэмжин ажиллахаа М.Энхсайхан илэрхийлэв.

2004 оны 9 дүгээр сард Бээжинд зохиогдсон Азийн улс төрийн намуудын III симпозиум дээр МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Идэвхитэн, Иргэний Зориг Намын дарга С.Оюун, Монголын Ардчилсан Намын дарга Л.Гансүх нарын 3 намын төлөөлөгчид хуралд оролцож, хурлын үеэр ХКН-ын ТХ-ны УТТ-ны БХ-ны гишүүн, БНХАУ-ын дэд дарга Зэн Цинхун Монголын улс төрийн 3 намын төлөөлөгчидтэй уулзсан. Зэн Цинхун хэлэхдээ, Хятад, Монгол хоёр улсын улс төрийн нам, улс төрчдийн хооронд харилцаа, солилцоо үргэлжид хадгалагдаж байдаг нь биенээ улам бүр ойлгох, найрамдлыг хөгжүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг урагшлуулахад чухал нөлөө үзүүлсээр байдаг. Хятад, Монголын найрамдал, хамтын ажиллагаа нь цаг үе, хөгжлөө дагаад улам бүр өнөд бэхжих болно гэв. Хурлын үеэр Монголын Иргэний Зориг Нам ХКН-тай нам хоорондын харилцаа байгуулав.

2006 оны 12 дугаар сард намын дарга Ц.Элбэгдорж тэргүүтэй Монголын Ардчилсан намын төлөөлөгчид Хятад улсад айлчилж, ХКН-ын ТХ-ны УТТ-ны БХ-ны гишүүн, УТЗЗ-ийн дарга Зя Цинлинь Монголын Ардчилсан намын төлөөлөгчидтэй уулзав. Зя Цинлинь хэлэхдээ, Хятад, Монгол хоёр бол хөрш улс бөгөөд хоёул хөгжиж буй орнууд юм. Хоёр улсын сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх нь улс төр, соёл, нийгмийн бат бөх суурь болж өгнө гэв. Ц.Элбэгдорж хэлэхдээ, Монгол, Хятадын найрамдлыг бүх талаар хөгжүүлэхэд өндөр ач холбогдол өгдөг нь шинэ зууны Монгол Улсын гадаад бодлогын гол чиглэл, Монголын дотоод улс төрийн намуудын нэгдмэл ойлголт мөн. Ардчилсан нам бол Хятад улстай харилцах найрсаг харилцаанд түлхэц үзүүлэгч гол хүч бөгөөд Монгол, Хятадын харилцааг бүх талаар гүнзгийрүүлэхэд идэвхтэй чармайх болно гэдгээ илэрхийлсэн юм.

2009 оны 6 дугаар сард Хэ Гуоцяныг Монголд айлчлах үеэр МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат, Иргэний Зориг намын дарга С.Оюун, Үндэсний Шинэ намын дарга С.Цолмон нар

тус бүр уулзсан. Уулзалтын үеэр, ХКН бол Монголын бүх улс төрийн намуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх явдлыг ямагт чухалчлан үздэг гэдгээ Хэ Гуоцян дарга цохон тэмдэглэсэн. Гурван намын удирдлага ч Монголын улс төрийн намууд дотоод асуудал дээр улс төрийн зөрөөтэй байр суурь баримталдаг ч Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэлцсэн, түншлэлийн харилцааг хөгжүүлэх асуудлаар нэгдмэл ойлголттой байдаг, ХКН-тай найрсаг харилцаагаа үргэлжлүүлэн бэхжүүлж, Монгол, Хятадын харилцааг хөгжүүлэхэд хамтран түлхэц үзүүлэх болно гэдгээ илэрхийлэв.

Эдгээр нам хоорондын харилцаа дахин сэргэж, өндөр түвшний харилцаа тогтмолжиж байгаа нь улс хоорондын харилцааны хөгжилд ихээхэн түлхэц үзүүлээд зогсохгүй талуудын ойлголцлыг гүнзгийрүүлэх, талуудын хамтын ажиллагааны үндэс суурь болж өгч банья.

### **Гурав. Нам хоорондын харилцаа нь хоёр улсын бүхий л салбарын харилцааг бүх талаар хөгжүүлэхэд түлхэц үзүүлнэ**

#### 1. Хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа

Хятад, Монголын намууд хоорондын харилцааны хөгжил нь юуны өмнө хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа урьд өмнө байгаагүйгээр хөгжихөд биеллээ олов. Монголын Статистикийн төв газраас гаргасан мэдээлэлд, 2008 онд Хятад, Монголын хоёр талын худалдааны нийт эргэлт 2,535 тэрбум<sup>2</sup> ам.долларт хүрсэн нь Монголын гадаад худалдааны нийт эргэлтийн 43,86 хувийг эзэлж байна. Хятад улс 10 жил дараалан Монголын хамгийн том худалдааны түнш болов. Хятад, Монголын тал өөрсдийн харьцангуй давуу байдлаа ашиглан бий болгосон худалдааны нягт харилцаа нь илэрхий бие биенээ нөхсөн шинж чанартай юм.

Хөрөнгө оруулалтын салбарт 2008 оны эцэс гэхэд Хятад улсын Монголд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 1,68 тэрбум ам.долларт<sup>3</sup> хүрч, хөрөнгө оруулалтын төсөл нийт 4628 байна. Монгол Улсад хөрөнгө оруулж буй хэмжээ, хэрэгжүүлж буй төслийнхөө тоогоор Хятад улс тэргүүлэх байранд орж байна. Гэвч Хятад улсаас Монголд оруулж байгаа хөрөнгө оруулалтын төслийг тооноос чанар луу шилжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна. Хятад улсын Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын төсөл байгаль орчныг хамгаалах, татвар төлөх зэрэг асуудлаар Монголын талын дургүйцлийг төрүүлдэг бөгөөд уг асуудал хоёр талын онцгой анхаарлыг татаж байдаг.

#### 2. Соёл, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир зэрэг зөөлөн хүчний талаарх хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа

Соёлын талаар: 2004 оны 4 дүгээр сард Монголд анх удаагаа “Хятадын соёлын 7 хоног” арга хэмжээг зохиож, Хятадын Соёлын

сайд Сунь Зяжэн тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, уг арга хэмжээнд оролцсон юм. 2005 оны 4 дүгээр сард Монголын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хятадын Соёлын яамтай хамтран Хятад улсын нийслэл Бээжин, Тяньжин хотуудад “Монголын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулсан. Хятадын Соёлын сайд Сунь Зяжэн, Монголын БСШУ-ны сайд Цагаан нар нээлтийн ёслолын ажиллагаанд оролцсон. Хоёр улс соёлын өдрүүдийг хоёр талдаа амжилттай зохион явуулсан нь хоёр орны ард түмний ойлголцол, найрамдлыг гүнзгийрүүлж, хоёр улсын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцааны агуулгыг баяжуулсан.

Боловсролын талаар: 1998 онд Хятад, Монгол хоёр улс “Хятад, Монголын Засгийн газар дээд боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Хэлэлцээр” байгуулав. 2000 онд хоёр улс мөн “Хятадын буцалтгүй хөрөнгөөр Монголын оюутнуудыг сургах төслийн хэрэгжилтийн хөтөлбөр”-т гарын үсэг зурав. 2005 онд хоёр тал “БНХАУ, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамд хоорондын 2005-2010 хүртэлх боловсролын солилцоо, хамтын ажиллагааны хөтөлбөр” байгуулав.

Хоёр улсын боловсролын баримт бичгүүд байгуулагдаж, хэрэгжиж эхэлснээр сүүлийн жилүүдэд хоёр улсын хооронд оюутан, аспирантур, зочин судлаачдыг харилцан сургах тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Өнөөдөр Монгол Улсын 2 мянга орчим оюутан Хятад улсын 100 гаруй их сургуульд боловсрол мэдлэг эзэмшиж байна. Хятадын талаас Монголд улсын болоод хувийн зардлаар суралцагчдын тоо жил бүр 100-д хүрч байна. Өвөр Монголд гэхэд 2005 онд Өвөр Монголын Ардын Засгийн газраас Монгол Улсад зориулж Засгийн газрын бүрэн тэтгэлэгийг бий болгож, жил бүр үндсэн ангийн 100 оюутанг хүлээн авч Өвөр Монголын их, дээд сургуулиудад сургаж байна. Энэ үндсэн дээр 2008 оноос эхлэн энэ тоог нэмэгдүүлж жил бүр 80 оюутныг Хятадын Засгийн газрын тэтгэлгээр докторантур, магистрантурт сургаж байна. Үүнээс гадна Өвөр Монголын 37 сургуульд Монголоос ирсэн 1000 гаруй оюутан сурагчдыг Өвөр Монголын их дээд, бага, дунд сургуулиудад хүлээн авч сургаж байна. 2008 онд хоёр тал “Олон улсын хятад хэлний багш, Хятадын сайн дурынхныг Монголд багшлуулах тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурав. Түүнчлэн 2008 оны 5 дугаар сард МУИС дээр Күнзийн Институт үүд хаалгаа нээв. Өнөөдрийг хүртэлх хугацаанд Хятадын Төрийн Зөвлөлийн харьяа Хилийн чанадад хятад хэлийг сурталчлах газар (Хань Бань)-аас 172 хятад хэлний багш, сайн дурынхан, улсын зардлаар 23 багш Монгол Улсад очоод байгаа бөгөөд тус улсад хятад хэлний 400 гаруй багш нар байна.

Энд онцлон тэмдэглүүштэй нэг зүйл гэвэл Монголын Засгийн газрын урилгаар Сычуаний газар хөдлөлтөд нэрвэгдсэн бүс нутгийн

60 хүүхэд 2009 оны 7-8 дугаар сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод нэг 7 хоногийн хугацаатайгаар амарч, сувилуулсан. Алс хол Сычуаний газар хөдлөлтийн бүсээс ирсэн хүүхдүүд Монгол Улсад нэгэн 7 хоногийг маш сайхан өнгөрүүлсэн юм. Тэднийг Улаанбаатараас явах үед Олон улсын “Найрамдал” зуслангийн багш, сурагчид салж ядан, үдэж мордуулсан. Монголын Засгийн газраас зохион байгуулсан Сычуаний газар хөдлөлтийн бүс нутгийн хүүхдүүдийг сувилж, амраасан энэхүү арга хэмжээ нь Хятадын гамшгийн бүс нутгийн хүүхдүүдийн бие сэтгэлийг тайвшруулсан төдийгүй Монгол, Хятадын найрамдал бага балчираасаа батжин бэхжихэд тустай үйл явдал болсон.

Эрүүл мэндийн талаар: Хамгийн сүүлийн үеийн нэгэн жишээ л татахад, Хятад улс Монгол Улсад “Найрамдлын мэлмий аян”-ыг зохион байгуулав. 2009 оны 6 дугаар сард хятадын 5 эмч, сувилагчаас бүрдсэн эмчилгээний баг Улаанбаатар хотноо хүрэлцэн очиж, 48 өвчтөнд хараа оруулах мэс заслыг үнэ төлбөргүйгээр хийв. Өвчтнүүдийн хамгийн бага нь 1 нас ч хүрээгүй, хамгийн өндөр настай нь 86 хөгшин байлаа. “Хятад, Монголын найрамдлын мэлмий аян” нь тэдний мэлмийг улам бүр тод болгон өгч, ертөнц дэлхийг өнгө бүрээр харах амьдралыг бэлэглэж өгсөн юм.

Биеийн тамир: Хамгийн сонгодог жишээг дурдвал, Монголчуудын бахархдаг тамирчид нь Бээжингийн зуны 29 дэх Олимпын үеэр 2 алт, 2 мөнгөн медаль авч Олимпын түүхэнд бахдам сайхан амжилт үзүүлсэн нь Олимпын алтан медаль авах гэсэн хүсэн хүлээлт нь биелсэн юм. Бээжингийн Олимп нь баяр хөөр, инээд баяслыг авчирж, бүх монголчуудын хамгийн ярих дуртай сэдвийн нэг болж байна. Бээжингийн Олимп нь Монгол Улс, Хятадын улсын хоорондын зайг ойртуулж, Монголын Хятадын талаарх сайхан сэтгэгдлийг бэхжүүлж өгөв.

**ДҮГНЭЛТ:** Дээрх бүгдийг дүгнэн хэлбэл, Хятад, Монголын шинэ хэлбэрийн нам хоорондын харилцаа, нам хоорондын нягт харилцаа нь Хятад, Монгол хоёр улсын харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд Хятад, Монголын улс хоорондын харилцааны хөгжилд чухал нөлөө үзүүлсээр байгаа төдийгүй хоёр улсын бүхий л салбарын хөгжилд хүчтэй түлхэц үзүүлж байна.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Зүн лиан ян 钟廉言 : ХКН-ын гадаад харилцааны 60 жил”, “лиао ван 瞭望” 2008, №31
2. Эх сурвалж: МУ-ын Статистикийн эмхэтгэл-2008, [http://www.statis.mn/bull/2008/bulletin\\_2008\\_dec.pdf](http://www.statis.mn/bull/2008/bulletin_2008_dec.pdf)
3. 中国外交部网 <http://www.fmprc.gov.cn/chn/wjb/zzjg/vzs/qjlb/1261/1261x0/default.htm>